



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 09 сар | Дугаар 34

ГАРЧИГ

- 2–3** Бодлогын нийтлэл
- 4–6** Зохицуулалтын мэдээ
- 7–9** Цар тахлын нөхцөл дэх хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын орчин
- 10** ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ
- 11–12** НОГООН ДААТГАЛ
- 13–15** ЯПОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ
- 16–17** ЦУВРАЛ ХИЧЭЭЛ
- 18** ХЭРЭГЛЭГЧ
- 19** ЗАСАГЛАЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГТ АНХААРАЛ ХАНДУУЛАХ НЬ
- 20–22** Олон улсын зах зээлийн

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол


- Засгийн IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ЦАХИМ ФОРУМ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд 2020 оноос эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогоор зохицуулж, эрсдэлд суурилсан хэлбэрээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болох дээрх хоёр салбарын оролцогчдын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ үйл ажиллагаатай холбоотой чадавхыг бэхжүүлэх, салбарт тулгамдсан асуудал, тэдгээрийн шийдлийг хэлэлцэхээр мэргэжлийн холбоодтой хамтарсан форумыг цахимаар зохион байгууллаа. Тодруулбал, энэ сарын 23-ны өдөр Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоотой хамтарсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчдын МУТСТ үйл ажиллагаа-2021” форумд 171, харин Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоотой хамтарсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн МУТСТ үйл ажиллагаа-



2021” форумд 82, олон нийтийн сүлжээгээр 1,270 гаруй оролцогч буюу нийтдээ төр, хувийн хэвшлийн 1,523 төлөөлөл хамрагдлаа.

Тус форумын үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос МУТСТ чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого зохицуулалт, хяналт

шалгалтын талаарх мэдээллийг өгсөн бол Терроризмтой тэмцэх зөвлөлөөс “Санхүүгийн хориг арга хэмжээ”, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас “Гүйлгээний хяналт, гүйлгээний тайлан”, Алтны бичил уурхайн зөвлөлийн Планет голд хөтөлбөр “Магадлан шинжилгээ болон Крафт код” сэдвээр тус тус илтгэл тавьж, мэргэжлийн холбоод өөрсдийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийв.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан форумыг нээж үг хэлэхдээ амаргүй нөхцөл байдалд биетээр биш хэдий ч цахимаар нэг дор хуран цугларсан оролцогчиддоо талархал илэрхийлээд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа МУТСТ үйл ажиллагаанд багагүй үүрэг оролцоотой болохыг дурдсан юм. Мөн форумын үеэр оролцогчдын мэдлэгийг бататгах зорилготой “Асуулт, хариулт”-ын хэсгийг амжилттай зохион байгуулж панел хэлэлцүүлгээр оролцогчид илтгэгчдээс нээлттэй асуулт, хариулт өрнүүлж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн МУТСТ эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээ, гадны орнуудын оновчтой зохицуулалтын талаар хэлэлцэж, салбарын цаашдын хөгжил, чиг хандлагын талаар санал бодлоо хуваалцлаа.

Ургэлжлэл 3-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ШИНЖЭЭЧ

Аливаа үйл ажиллагааны өнгөрсөн, одоогийн тоон болон бусад мэдээлэл эсвэл үйл ажиллагааны гүйцэтгэлд түшиглэн судалгаа шинжилгээ хийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлодог мэргэжилтэн.



ANALYST

A person trained to examine statistics and other information regarding past, present, and future trends or performance of an operation.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН ДЭЛХИЙ ДАХИНД

Хадгаламж, зээлийн хоршоо нь гишүүдийн хувь зэмшилтэй, ихэвчлэн олон нийтийн оролцоотой санхүүгийн зуучлагчид байдгийн хувьд орон нутгийн хөгжил, эдийн засагтай нягт уялдаж, харилцан зохицож ажилладаг бөгөөд ялангуяа хямралын үед илүүтэйгээр хариу үйлдэл үзүүлэх боломжтой байдаг. Гэхдээ цар тахлын нөхцөл байдлын үед тэдний бизнесийн загварт шинэ сорилт тулгарч байна.

Хямралын үед хуримтлал төвлөрүүлэх, зээл олгоход хадгаламж, зээлийн хоршоод ямар үүрэг гүйцэтгэх талаар болон бага орлоготой иргэдэд хадгаламж, зээлийн хоршоодын хүргэх тус, ач холбогдол, тэдний цар тахлыг даван туулахад гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь чухал юм.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (WOCCU)–оос авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU) нь 2020 оны эцсээр Ковид–19 цар тахлын эсрэг дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж буй бүхий л хадгаламж, зээлийн хоршоодод тусламж, дэмжлэг үзүүлэх хороог байгуулж ажиллажээ. Тус хорооны зорилго нь хадгаламж, зээлийн хоршоодод цар тахлын үед ашиглах шилдэг туршлага ба стратегийг тодорхойлох юм.

Тус хороо нь дараах арга хэмжээг авч ажиллахаар зорьсон байна. Үүнд:

- Гишүүдэд ухуулга сурталчилгаа хийх;
- Гишүүдийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах;
- Цахимжуулалт;
- Олон нийтийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Бизнесийн тасралтгүй байдлыг хангах зэрэг болно.

Ойрын 2–3 жилийн хугацаанд хийхээр төлөвлөж байсан хадгаламж, зээлийн хоршоодыг цахимжуулах ажлыг яаралтай хэрэгжүүлэх нөхцөл байдал тулгарсантай холбоотойгоор WOCCU болон Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл (ICURN)–оос хэд хэдэн чуулга уулзалтуудыг цахимаар зохион байгуулаад байна. Цахим чуулга

уулзалтуудаар дэлхий дахинд цар тахлын улмаас үүссэн хямралын үед хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн аюулгүй байдлыг хадгалах зорилгоор жижиг хадгаламж, зээлийн хоршоодыг цахим хэлбэрт шилжүүлэх хэрэгцээ шаардлага ба хянан зохицуулагчдын дэмжлэгийн талаар, мөн тэдний цахим сонор сэрэмжийг хэрхэн нэмэгдүүлэх тухай хэлэлцсэн. тус байгууллагаас жил бүр зохион байгуулдаг ээлжит хуралд хэлэлцэх Ковид–19 цар тахалтай холбоотой хязгаарлалт болон шинэ арга замуудын талаар мэдээлэл өгсөн. Үүнд:

- **Цахим сувгууд:** Гишүүдэд интернет банк, мобайл банк, онлайн төлбөр тооцоо хийх, онлайнар зээл авах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг бэлэн мөнгөний гүйлгээг цахимжуулах;
- **Цахим төлбөр төлөлт:** Хадгаламж, зээлийн хоршоодыг цахимаар төлбөр төлөх боломжтой, үндэсний төлбөрийн системтэй нэгтгэж холбох;
- **Мэдээллийн шинжилгээ:** Гишүүдэд ямар нэмэлт үйлчилгээ үзүүлэхийг тодорхойлох, санхүүгийн мэдлэг, зөвлөгөө, үйлчилгээг авах шаардлагатай хүмүүсийг тодорхойлох зорилготой мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- **Кибер аюулгүй байдал:** Хадгаламж, зээлийн хоршоо ба гишүүдийн мэдээллийг цахим халдлага, гэмт хэргээс хамгаалах, тухайн улсын зохицуулалтад нийцсэн кибер аюулгүй байдлын системийг хөгжүүлэх.

Мөн дээрх арга хэмжээний зорилгын хүрээнд 9 чиглэлээр зөвлөмж боловсруулсан. Үүнд:

1. **Уян хатан зохицуулалт хийх:** хэвийн нөхцөл байдал өөрчлөгдсөн гэдгийг хүлээн зөвшөөрч, эрүүл мэндийн хямралыг даван туулж, үйл ажиллагаагаа хүндрэлгүй явуулах боломжийг олгох уян хатан зохицуулалт хийхийг зохицуулагч байгууллагуудад уриалсан;
2. **Зайлшгүй шаардлагатай асуудлуудыг тодорхойлох:** хамгийн чухал, зайлшгүй хийгдэх шаардлагатай үйл ажиллагаанаас бусдыг хязгаарлах;
3. **Хөрөнгийн шаардлага, стандартуудыг тодорхойлох:** Базелийн хорооноос

капитал ба нягтлан бодох бүртгэлийн стандартад холбогдох бусад асуудлаар тодорхой өөрчлөлт оруулах удирдамжийг боловсруулж, нийцлийн огноог өөрчилсэн;

4. **Нягтлан бодох бүртгэлийн стандартыг тодорхойлох:** СТОУС 9–ийн хэрэглээтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор “Стандарт 9 ба COVID–19 цар тахлын улмаас үүссэн өнөөгийн тодорхойгүй байдлын үүднээс СТОУС 9–ийн санхүүгийн хэрэгслийг ашиглаж хүлээж болох зээлийн алдагдлыг (ECL) тооцох нь” баримт бичгийг боловсруулж, хэвлэн нийтэлсэн;

Хямралын үед тогтмол төлбөр хийхгүй байх магадлалтай байдаг тул үүнийг харгалзан үзэж гар дээрх бэлэн мөнгөний гүйлгээний нөлөөллийг тооцох;

Хоршоод төлбөрийн чадварынхаа эх үүсвэрт дүн шинжилгээ хийж, ТТГЧ–ыг хангуулахын тулд төв банк болон зохицуулагч байгууллага нь ямар хөнгөлөлт, урамшуулал үзүүлж байгааг судалсан байх; Хоршоод гишүүдийнхээ хөрөнгийг хэрхэн найдвартай, аюулгүй хамгаалдаг, гэртээ бэлэн мөнгөө нууцаар хуримтлуулах, нөөцлөх шаардлагагүй талаар тайлбарлан, мэдлэг олгох хэрэгтэй. Төв банк

Дэлхийн зарим улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ: Их Британийн хадгаламж, зээлийн хоршоод гишүүдийнхээ санхүүгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж бүтээлч байдлаар ажиллаж, олон тооны жижиг, дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бизнесийг нь аварч чаджээ. Жишээлбэл, бизнесээ цахимаар явуулж чадахгүй эмзэг бүлгийн гишүүдийн гүйлгээг хөнгөвчлөх; бизнесийн яаралтай зээл олгох; гишүүдэд зориулсан Ковид–19 мэдээллийн төв байгуулах; гишүүдэд одоо байгаа өр төлбөрөө нэгтгэх, эргэн төлөх нөхцөл боломжийг олгох зорилгоор хямд өртөгтэй санхүүжилт гаргах зэрэг арга хэмжээ авсан байна. Гэхдээ Их Британийн зарим хадгаламж, зээлийн хоршоодын орлогын түвшинд харгалзах өртөг өндөр, хөрөнгийн өгөөж бага, зээлийн багцын чанар муудсан нь капиталжуулалтын асуудалд хүргэж, салбарын хэмжээнд нэгтгэн нийлүүлэх (consolidation) арга хэмжээ авахад хүргэж болзошгүй юм. Ковид–19 цар тахал нь цахим санхүүгийн шийдлүүдээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах явдлыг хурдасгаж байна. Их Британийн ихэнх хадгаламж, зээлийн хоршоод дижитал сувгаар дамжуулан санхүүгийн үйлчилгээг үзүүлэх түвшинд хүрээгүй тул тэдний орон зай “финтек”–ийн санхүүгийн технологийн үйлчилгээ үзүүлэгчдэд шилжиж болзошгүй эрсдэлтэй тулгарсан байна.

Их Британид 2020 оны 2 дугаар улирлын эцэст ойролцоогоор хоёр сая насанд хүрсэн гишүүнтэй 418 хадгаламж, зээлийн хоршоо (Англид 173, Шотландад 87, Уэльсэд 16, Умард Ирландад 142) байсан. Эдгээр нь нийт 3.81 тэрбум фунт стерлингийн хөрөнгөтэй /актив/ байжээ (үүний 49% –ийг Умард Ирландын зээлийн хоршоод эзэмшиж байсан). Их Британийн хадгаламж, зээлийн хоршоод энэ үед гишүүддээ 1.59 тэрбум фунт стерлингийн зээл олгосон бөгөөд гишүүдийн дундаж зээл Хойд Ирландад хамгийн өндөр буюу 3767 фунт стерлинг, хамгийн бага нь Уэльсэд 1460 фунт стерлинг байв (Английн төв банк, 2020).

5. **Мэдээллийн технологийн асуудлыг тодорхойлох:**

Мэдээллийн технологийн дэд бүтэц: Мэдээллийн технологийн дэд бүтэц нь уртасгасан цагаар хэрэглээний огцом өсөлтийг дэмжиж чадах эсэхийг хянан баталгаажуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авах;

Гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчид: гадны үйлчилгээ үзүүлэгчид эсхүл чухал ханган нийлүүлэгчдэд тохирох арга хэмжээ авч, тэдний үйлчилгээнээс хэтэрхий хамааралтай байдлыг бууруулах, эрсдэлтэй үед хангалттай бэлтгэлтэй байх;

Кибер уян хатан байдал: Соноор сэрэмжтэй байхын тулд эмзэг системийг олж илрүүлэх, хамгаалах, кибер халдлагыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн засах чадвартай байх.

6. **Тусламж хэрэгтэй байгаа гишүүдэд дэмжлэг үзүүлэх:**

Зээлийн бүтцийн өөрчлөлт: төлбөрийн хугацааг сунгах, хүүг бууруулах, зөвхөн хүүгийн төлбөр авах, зээлийг өргөтгөж сунгах;

Өр төлбөрийг нэгтгэх;

Хямралын үед зориулж бага хүүтэй зээл олгох, урьдчилгаа санхүүжилт олгох;

Шимтгэл хураамжаас чөлөөлөх;

Хадгаламжийн сертификатын цуцлалтаас торгууль буцаан авахгүй байх;

Даатгалын үйлчилгээ үзүүлэх;

Санхүүгийн зөвлөгөө өгөх;

Нууцлах шаардлагатай болон мэдээллийн өгөгдлөө хамгаалах зааварчилгаа өгөх буюу луйврын гүйлгээнээс сэргийлэх;

Эрүүл мэндийн талаарх заавар, мэдлэг олгох.

7. **Хөрвөх чадварыг хамгаалах:**

Хоршоод одоогийн мөнгөн хөрөнгө /хөрвөх чадварын нөхцөл байдал дээрээ дүн шинжилгээ хийж шаардлагатай мөнгөн хөрөнгийн хэмжээг зохих хязгаараар тогтоох (өөрөөр хэлбэл нэг өдөрт байх / долоо хоног/ сард эсвэл тодорхой хугацаагаар, валют, бүтээгдэхүүн тус бүрээр);

болон зохицуулагч байгууллагууд дээрх чиглэлээр хоршоодод тусламж, дэмжлэг үзүүлэх;

Хадгаламжийн даатгал болон баталгааны тогтолцооны гарц байгааг онцлон тэмдэглэх;

Зохицуулагч байгууллагатай нягт уялдаатай хамтран ажиллахыг уриалж, мөнгөн хөрөнгийн гарах урсгалыг түр хойшлуулах боломжтой эсэхийг судлах;

Хоршоодын үйлчилгээний цагийг тохируулах боломжийг олгож, уян хатан хандах;

Хямралын үед “АТМ”–тэй хоршоод бэлэн мөнгөөр зузаатгал хийхэд хүндрэлтэй байж болзошгүйг тооцож, анхааралдаа авах хэрэгтэй.

8. **Тайлан гаргахад тавигдах шаардлагыг хөнгөвчилсөн байдлаар тодорхойлох:**

Тайлагналыг хойшлуулахдаа зохицуулалтын байгууллага тайлан гаргах эцсийн хугацааг хойшлуулах замаар хэрэгжүүлж байна. Үүнд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн тайлангууд;

Татварын тайлангууд;

Байнгын шалгалтын тайлангууд;

Аудит шалгалтын тайлангуудын хугацааг хойшлуулах зэрэг.

9. **Зохицуулалтуудыг хөнгөвчлөх:**

Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх дэмжлэг болон ажлын байрыг хадгалахад туслах;

Засгийн газраас санхүүжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн шаардлага, шалгууруудыг бууруулах;

Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, Зээлийн хорооны болон бүх гишүүдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахыг дэмжиж, зөвшөөрөх зэрэг болно.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

Эхлэл 1-р нүүрт >>

САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН НИЙТЛЭГ ТӨРЛҮҮД БА ТЭДГЭЭРИЙН ШИНЖ

Өндөр ашиг, үр өгөөж амласан төрийн зохицуулалтгүй криптовалют, биткойн, виртуал хөрөнгөтэй холбоотой аливаа үйл ажиллагаанаас болгоомжилж өөрийгөө болон бусдыг аливаа эрсдэлээс хамгаалахыг Санхүүгийн зохицуулах хорооноос анхааруулж байна.



ярилцаж санал бодлоо солилцсон юм.




САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо хүртээмжтэй, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлт, хөгжлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн

болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр байна. Энэхүү ажлын хүрээнд өнөөдөр Санхүүгийн зохицуулах хороо МУИС-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, МУИС-ын захирал Б.Очирхуяг нар үзэглэж, зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бодлого зохицуулалтын оновчтой зөв шийдвэр гаргахад түлхэц болсон хамтарсан судалгаа, шинжилгээ хийх цаашилбал гадаад, дотоодын төсөл хөтөлбөр болон салбарын хөрөнгө оруулалтад шаардлагатай зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцлоо.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН АНХДУГААР ЦАХИМ ФОРУМ БОЛЛОО



Монголын хадгаламж, зээлийн хоршоодын анхдугаар цахим форумыг “Дэлхийн жишиг хоршооны хөгжлийг нутагшуулах нь” сэдвийн хүрээнд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос зохион байгууллаа.

Цахим форумд нийслэл болон орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоодоос гадна Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо, Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо, Дэлхийн байгаль хамгааллын сангийн төлөөлөл оролцож, салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний талаар хэлэлцээд форумаас гаргасан санал, уриалга, шийдлүүдийг нэгтгэн хэлэлцүүлэг хийлээ. Мөн энэ үеэр орон нутгийн хоршоодоор дамжуулж байгаль экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах үйлсэд иргэдийг татан оролцуулсан сайн туршлагын талаар



бусад судалгаа, шинжилгээг хийх, зах зээлийн хөгжлийн ирээдүйн чиг хандлагын талаар таамаглал дэвшүүлэх загварчлалыг хамтран гаргахаар зорьж байна. Бидний хамтын ажиллагаа үр өгөөжтэй байх болтугай” гэсэн юм. Харин МУИС-ын захирал Б.Очирхуяг “Салбарын хөгжил дэвшил, шинэ технологи, хөрөнгө оруулалт, эрх зүйн орчны болон салбар дундын

судалгааны ажил хийх, судалгаандаа ахисан түвшний оюутнуудыг оролцуулах, төсөл хөтөлбөр, олон талт зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллах болсондоо нэн талархалтай байна” гэдгийг онцолсон юм.

Хоёр тал хамтын ажиллагааны хүрээнд мөн санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд дэлгэрүүлэхэд шаардлагатай судалгаа хийх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан сургалт зохион байгуулах, техник арга зүйн туслалцааны хөтөлбөрүүд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ



Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлаас үүдэж манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон сорилтууд тулгарсан ч хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, арилжааны хэмжээ, индексийн үзүүлэлтүүд сүүлийн үед түүхэн дээд түвшинд хүрээд байна.

Зах зээлийн үнэлгээ өнгөрсөн сард 4.0 их наяд төгрөгт хүрч, үндэсний томоохон компанийн үнэлгээ 1.0 их наяд төгрөг хүрсэн бол есдүгээр сарын 08-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК дээрх зах зээлийн үнэлгээ хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөн 30 жилийн түүхэнд хамгийн дээд түвшинд буюу 5.0 их наяд төгрөгт хүрлээ.

УИХ, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг дэмжиж ажилласны үр дүнд Санхүүгийн зохицуулах хороо зах зээлийн мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч нартай хамтран хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаас хөрвүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоог бүрдүүлэх чиглэлд бодлогын томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлсэнээр ийнхүү зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд хүрээд байна. Энэхүү өсөлтөд цөөн тооны хувьцаат компаниудын үнэлгээнээс илүүтэй иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд итгэх итгэл сэргэж, арилжаанд оролцох идэвх нэмэгдэж, бүртгэлтэй хувьцаат компанийн нийт үнэлгээ өссөнийг онцлох нь зүйтэй.

Цаашид ч УИХ-аас баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хүрээнд зээлийн хүү үе шаттайгаар буурах, системийн нөлөө бүхий банкууд ирэх онд хувьцаат компани болж, хувьцааг нь арилжаа эрхлэх байгууллагаар дамжиж олон нийтэд арилжсанаар зах зээлийн үнэлгээ улам нэмэгдэх, түүнийг дагаад бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, урт

хугацааны санхүүжилтийн цогц тогтолцоо илүү сайжрах боломж бүрдэх юм.


Цаашилбал, өрхийн санхүүгийн чадамжаас давсан, өр, зээл үүсгэсэн харилцааг зохицуулах, хэрэглэгчдийг хохироосон өндөр хүүтэй зээл олголтын эсрэг хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатайг онцлоод бүрэн эрхийнхээ хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ




Олон улсын валютын сан /ОУВС/-гаас гишүүн орнуудтайгаа тухайн улс орны эдийн засаг, санхүүгийн бодлогын төлөв байдлыг зөвлөлдөх, үнэлэх хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн бодлогын төлөв байдлын талаарх хэлэлцүүлэг энэ сарын 7-ны өдөр цахимаар болж ОУВС-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Сөк Юүн (Seok Hyun Yoon), Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч Ангана Банержи (Angana Banerji), бусад шинжээч судлаачид Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны болон зарим газрын дарга нартай уулзаж санал бодлоо



солилцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлэлцүүлгийг нээж “Халдварт цар тахлын нөлөөллөөс үүдэж Монгол Улсын санхүү, эдийн засгийн салбар амаргүй нөхцөл байдалтай тулгарсан ч Санхүүгийн зохицуулах хороо зохих арга хэмжээг шуурхай авч ажилласнаар нэлээдгүй ахиц дэвшил үзүүлээ. Тухайлбал, санхүүгийн салбар 4.2 нэгжээр өсөж, тэр дундаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 4.9 их наяд төгрөгт хүрлээ. Мөн хөрөнгийн зах зээлд хувийн хэвшлээс компанийн бонд, анхны арилжааны зориулалттай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, биржээр арилжаалагддаг



хамтын хөрөнгө оруулалтын сан зэрэг шинэ бүтээгдэхүүн гарсан. Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үндэсний компанийн зах зээлийн үнэлгээ 1 их наяд төгрөгт хүрсэн түүхэн үйл явдал тохиолоо. Үүний зэрэгцээ биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг баталснаар нэгэн шинэ бүтээгдэхүүн гарч, Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд шинэ хуудас нээгдэж байна. Энэ нь санхүүгийн зохицуулагч байгууллага болон мэргэжлийн оролцогч байгууллагууд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид буюу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүн. Цаашид ч бид олон нийтийн оролцоог сайтар хангаж, ил тод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, баялаг бүтээгчдээ дэмжиж ажиллах болно” гэж хэлсэн юм.

Хэлэлцүүлгийн үеэр хоёр тал Монгол Улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүгийн тогтвортой байдлын чиглэлээр тулгамдаж буй асуудлын талаар ярилцлаа. Тодруулбал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд Санхүүгийн зохицуулах хорооноос хийж хэрэгжүүлсэн болон цаашид хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, дүрэм журмын орчинг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, цар тахалтай



тэмцэхэд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны болон даатгалын салбарт бодлогын түвшинд хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид

анхаарч буй асуудал, ББСБ-уудын зээлийн байдалд хийсэн үнэлгээний талаар санал солилцов.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /СТБЗ/-ийн 2021 оны III улирлын ээлжит хуралдаан 2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Сангийн яамны хурлын танхимд боллоо. Хуралдаанд Сангийн сайд Б.Жавхлан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал С.Баатарсүрэн болон холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Энэ удаагийн хурлаар Засгийн газрын дотоод үнэт цаасыг биржийн бус зах зээлээр дамжуулан арилжаалах тухай, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн талаар хэлэлцэж, мэдээлэл солилцлоо. СТБЗ-ийн гишүүд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлд холбогдох саналаа хүргүүлж, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах чиглэлд хамтран ажиллахаа мэдэгдэв.

Мөн үйл ажиллагааг нь албан ёсоор эхлүүлсэн биржийн бус зах зээлийн талаар мэдээлэл, танилцуулга сонсоод зөвлөлөөс цаашид энэ ЗАХ зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжиж ажиллахаа илэрхийллээ.

МОНГОЛ УЛСАД БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ АЛБАН ЁСООР ЭХЛҮҮЛЛЭЭ

Монгол Улсад биржийн бус зах зээлийн арилжааг албан ёсоор эхлүүлэх зан цохих ёслолын ажиллагаа энэ сарын 7-ны өдөр боллоо.

Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Жайка Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Тамүра Эрико, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва, болон холбогдох албаны бусад хүмүүс оролцсон юм.

УИХ, Засгийн газраас санхүүгийн зах зээлд өрсөлдөөнийг бий болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулж байгаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ тутамд үүсч байгаа санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжин, хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулж, бодлого, зохицуулалтаа чиглүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд Сангийн яам, мэргэжлийн холбоод, дэд бүтцийн байгууллагуудтайгаа хамтран үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлд тодорхой ажлыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал, Үнэт цаасны төлбөр тооцооны горим, зарчмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, DvP/T+2 дараа төлбөр тооцооны горимд амжилттай нэвтрүүлээ. Үнэт цаасны давхар бүртгэлийн систем буюу бирж хооронд үнэт цаасаа чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах орчинг бий болгосон.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан зан цохих ёслолын ажиллагааг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар олгогдсон

эрхийн дагуу Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг баталснаар биржийн бус зах зээл хөгжих эхлэл тавигдсаныг Та бүхэн мэднэ. Энэ журмаар Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг олгосон нь өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж төрийн зүгээс зарим чиг үүргээ шилжүүлж буй томоохон алхам юм. Ингэснээр олон улсын жишигт нийцсэн биржийн бус зах зээлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран хөгжүүлэх, биржийн бус зах зээлд шинэ бүтээгдэхүүн гарах боломж бий боллоо. Ийнхүү биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг эхлүүлснээр компанийн хаалттай өрийн хэрэгслийг зохицуулсан хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бий болохын зэрэгцээ компанийн хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх суурь тавигдаж, компаниудын зүгээс ч үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэх, мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт чиглэсэн зах зээл бий болох, ил тод нээлттэй мэдээлэл, хяналтын тогтолцоо бүрдэх зэрэг олон давуу талтай...” гэдгийг онцолсон юм.

Энэ сарын 3-ны өдрийн байдлаар үнэт цаас гаргагчийн 16.5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 5 хаалттай бондын захиалга амжилттай биелж, анхдагч зах зээлийн захиалга хаагдсан. Харин эдгээр бондын хоёрдогч зах зээлийн арилжаа нь өнөөдөр ийнхүү эхэлснээр компаниудын бондын хөрвөх чадвар сайжрах, өмчлөх эрхийн бүртгэл шилжих, арилжих боломж Монголын хөрөнгийн зах зээл дээр бий боллоо.

БАЙР СУУРЬ

ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах референт Д.Дашнямтай ярилцлаа.

Цар тахлын нөхцөл байдлын үе дэх зохицуулалтын орчны өөрчлөлтийн талаар яриагаа эхлэх үү?

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн амьдрал ихээр өөрчлөгдөж байгаатай адил санхүүгийн зах зээлийн зохицуулалт ч өөр шатанд очих шаардлага тулгарсан. Хэвийн үед зах зээлийн өсөлт, хөгжил ярьдаг байсан бол энэ цаг үед хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах шаардлага тулгараад байна. Нөгөөтээгүүр цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим эерэг өөрчлөлтүүд ч гарсаар байна. Тухайлбал: цахим шилжилт, зохицуулалтын хялбарчлал гэх мэт.

Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн нөхцөл байдал ямархуу дүр зурагтай байгаа вэ?

Зах зээлийн статистик, тоо баримтын хувьд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 234 хадгаламж, зээлийн хоршоонд 73,719 гишүүн бүртгэлтэй байгаагаас 32,534 нь зээлдэгч, 35,122 нь хадгаламж эзэмшигч гишүүн байна. Тайлант улирлын байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өсөж 270.4 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын 0.7 хувьтай, нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өсөж 186.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын 1.0 хувь, нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар өсөж 191.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын 1.0 хувьтай тэнцэж байна.

Эдгээр статистик тоо баримтыг цар тахлаас өмнөх нөхцөл байдалтай харьцуулж үзвэл зах зээлийн өсөлт саарч хэвийн үед 25–28 хувиар өсөж байсан нийт хөрөнгө, зээл, хадгаламжийн үзүүлэлтүүд зарим улиралд 5 хувийн, хамгийн ихдээ 17 орчим хувийн өсөлтийг үзүүлж байна. Гишүүдийн тоо дунджаар 10–12 хувийн өсөлттэй байсан бол 2 хувь болж өсөлт нь саарсан. Харин зээлдэгч, хадгаламж эзэмшигчийн тоо, нийт гишүүдэд эзлэх хувь тогтвортой хэвээр байна. Зах зээлд агшилт явагдаж байгаа хэдий ч ДНБ болон банкны зах

зээлийн үзүүлэлтэд эзлэх хувийг авч үзвэл харьцангуй тогтвортой байна.

Хадгаламж, зээлийн хоршооны хувьд гишүүнчлэлд тулгуурласан, хамтын шийдвэр гаргадаг онцлогтой байгууллага учраас хадгаламж эзэмшигч, зээлдэгч нар харилцан тохиролцож хоршооны үйл ажиллагаагаа тогтвортой байлгах хэлцлүүдийг хийж болдогоруу давуу талтай байдаг.

Ер нь цар тахлыг давж гарахын тулд олон улсад ямархуу арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа вэ?

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (WOCCU) нь 2020 оны эцсээр дэлхий дахинд үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л хадгаламж, зээлийн хоршоодод Ковид –19 цар тахлын эсрэг тусламж, дэмжлэг үзүүлэх хороог байгуулж ажилласан. Санхүүгийн зохицуулах хорооны зорилго нь хадгаламж, зээлийн хоршоодод цар тахлын үед ашиглах шилдэг туршлага ба стратегийг тодорхойлох юм. Энэ зорилгын хүрээнд гишүүдэд ухуулга сурталчилгаа хийх, гишүүдийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах, цахимжуулалт, олон нийтийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бизнесийн тасралтгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзээд зөвлөмж боловсруулж нийтэд мэдээлсэн байгаа.

Тус зөвлөмжөөс дурдвал?

Зорилтуудын хүрээнд 9 зөвлөмжийг боловсруулсан байсан. Тэдгээрийг нэг бүрчлэн тайлбарлая. Юун түрүүнд уян хатан зохицуулалт хийх буюу хэвийн нөхцөл байдал өөрчлөгдсөн гэдгийг хүлээн зөвшөөрч, эрүүл мэндийн хямралыг даван туулж, үйл ажиллагаагаа хүндрэлгүй явуулах боломжийг олгох уян хатан зохицуулалт явуулахыг зохицуулагч байгууллагуудад уриалсан. Түүний дараагаар хадгаламж, зээлийн хоршоодыг зайлшгүй хийгдэх шаардлагатай үйл ажиллагаанаас бусдыг хязгаарлахыг зөвлөсөн. Мөн Базелийн хорооноос нягтлан бодох бүртгэлийн стандартад тодорхой асуудлаар өөрчлөлт хийж, нийцлийн огноог өөрчилсөн байна. Дараагийн цар тахлын нөхцөл байдлын улмаас үүссэн

тодорхойгүй байдлын үүднээс хүлээж болох зээлийн алдагдлын талаар баримт бичиг боловсруулж, хэвлэн нийтэлсэн байна. За энэ нөхцөл байдалд хамгийн чухал бөгөөд хурдтай хөгжиж буй салбар бол мэдээллийн технологийн салбар. Тэгэхээр цахим шилжилттэй холбоотой мэдээллийн технологийн асуудлыг тодорхойлох шаардлага урган гарч байгаа талаар зөвлөөд мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах, үйлчилгээ үзүүлэгчдээс хэтэрхий хамааралтай байгаа байдлыг бууруулж, эрсдэлээ тооцох, кибер аюулгүй байдлыг хангаж, сонор сэрэмжтэй байх, хариу авах арга хэмжээг тодорхойлох чадвартай байхыг зөвлөсөн. Гишүүдэд тулгарч буй асуудлыг тодорхойлох буюу тусламж хэрэгтэй байгаа гишүүддээ дэмжлэг үзүүлэхийг зөвлөсөн.

Тодруулбал гишүүдэд ямар төрлийн тусламж, дэмжлэг үзүүлж болох талаар дурдсан байгаа бол?

Тухайлбал, зээлийн бүтцийн өөрчлөлт хийх, төлбөрийн хугацааг сунгах, хүүг бууруулах, зөвхөн хүүгийн төлбөр авах, зээлийг өргөтгөж сунгах, өр төлбөрийг нэгтгэх, хямралын үед зориулж бага хүүтэй зээл олгох, урьдчилгаа санхүүжилт олгох, шимтгэл хураамжаас чөлөөлөх, зарим торгуулийг авахгүй байх, даатгалын үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн зөвлөгөө өгөх, нууцлах шаардлагатай болон мэдээллийн өгөгдлөө хамгаалах зааварчилгаа өгөх буюу луйврын гүйлгээнээс сэргийлэх, эрүүл мэндийн талаарх заавар, мэдлэг олгох зэрэг арга хэмжээг багтаасан байна. Долоо дахь зөвлөмж бол санхүүгийн байгууллагын хөрвөх чадварыг хамгаалах бөгөөд хадгаламж, зээлийн хоршоод одоогийн хөрвөх чадварын нөхцөл байдал дээрээ дүн шинжилгээ хийх хэрэгтэй, шаардлагатай мөнгөн хөрөнгийн хэмжээг зохих хязгаараар тогтоох, хямралын үед тогтмол төлбөр хийхгүй байх магадлалтай байдаг тул үүнийг харгалзан үзэж, гар

дээрх бэлэн мөнгөний гүйлгээний нөлөөллийг тооцох, төлбөрийн чадварынхаа эх үүсвэрт дүн шинжилгээ хийж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулахын тулд төв банк болон зохицуулагч байгууллага нь хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх эсэх, гишүүддээ тэдний хөрөнгийг хэрхэн найдвартай, аюулгүй хамгаалж байгааг ойлгуулж, гэртээ бэлэн мөнгөө нууцаар хуримтлуулах, нөөцлөх шаардлагагүй талаар тайлбарлаж, мэдлэг олгох, хадгаламжийн даатгалыг хөгжүүлэх, хадгаламж, зээлийн хоршоодыг зохицуулагч байгууллагатай нягт уялдаатай хамтран ажиллахыг уриалж, мөнгөн хөрөнгийн гарах урсгалд түр хойшлуулалт тавих боломжийг судлах, үйлчилгээний цагийг тохируулах боломжийг олгож, уян хатан хандах зэргийг зөвлөсөн. Дараагийн тайлан гаргахад тавигдах шаардлагыг хөнгөвчилсөн байдлаар тодорхойлох буюу зарим тайлагналын хугацааг хойшлуулах арга хэмжээ авахыг зөвлөсөн. Эцэст нь зохицуулалтуудыг хөнгөвчлөх буюу хөрвөх чадварыг нэмэгдүүлэх дэмжлэг болон ажлын байрыг хадгалахад туслах, Засгийн газраас санхүүжүүлдэг төсөл, хөтөлбөрүүдийн зээлийн шаардлага, шалгууруудыг бууруулах, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны болон бүх гишүүдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахыг дэмжиж, зөвшөөрөх зэрэг зөвлөмж багтсан.

Тэгвэл Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?

Ерөнхийдөө бол зах зээлд тулгарч буй асуудал аль ч оронд адил төстэй учраас дээрх зөвлөмжтэй адилтгах хэмжээний зарим зохицуулалтыг хийсэн байгаа. Тухайлбал, Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт



шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нэмэлт оруулсан. Энэхүү өөрчлөлт нь нэн түрүүнд зээлдэгчийн зээлийн ангилал буурахаас хамгаалах зорилготой. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор зээлдэгчид зээлийн төлөлтөө хойшлуулах хүсэлтүүдийг хоршоондоо ирүүлж байгаа бөгөөд 2021 оны 8 дугаар сарын байдлаар зээлийн 14.8 хувийг хойшлуулсан байна. Энэ шийдвэрийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй журмын дагуу ангилах хүртэл үе шаттайгаар өөрчлөлт оруулсаар байна.

Олон улсад цахимжуулалт эрчимтэй явагдаж байгаа талаар түрүүн дурдсан. Тэгвэл энэ үйл ажиллагаа хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд хэр хурдацтай явж байгаа бол?

“Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Алсын хараа-2050” болон бусад баримт бичигт тусгасны дагуу зах зээлийн мэдээллийг цахимжуулах, төрөөс олгох тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг цахимжуулах ажил явагдаж байна. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулж 2021 оны 2 дугаар улирлын байдлаарх тусгай зөвшөөрөлтэй 222 ХЗХ-ны 64,181 гишүүний бүртгэлийг мэдээллийг бүртгээд байна. Гишүүдийн бүртгэлийг цахимжуулснаар Улсын бүртгэлийн ерөнхий газар болон төрийн бусад байгууллагуудтай цаашид мэдээлэл солилцох боломж нээгдэхийн зэрэгцээ цаг хугацаа, зардал хэмнэх ач холбогдолтой. Зөвхөн гишүүдийн мэдээлэл гэлтгүй хадгаламж, зээлийн хоршооны түүх, сонгуульт гишүүдийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээллийг цахим системд нийлүүлэх ажил эрчимтэй хийгдэж байна.

Харин цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй байхыг Санхүүгийн зохицуулах хорооноос уриалж анхааруулсан. Ер нь 2020 онд хийсэн судалгаагаар хадгаламж, зээлийн хоршоодын нийт гүйлгээний 70 гаруй хувь нь онлайнгаар хийгддэг болсон байсан бол цар тахлын нөхцөл байдлаас улбаалан энэ байдал илүү нэмэгдэж байгаа нь дамжиггүй.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах болон цахимжуулалтын ажил хийгдэж байгаа юм байна. Өөр ямар төрлийн шийдвэрүүд гарсан бэ?

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдүүлдэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд 2020 оны 12 дугаар сард нөөцийн сангийн зохистой харьцааг нийт хөрөнгөөс тооцох, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг хангах хувь хэмжээг бууруулах, мөн маягтуудыг шинэчлэх өөрчлөлтийг оруулсан. Энэхүү өөрчлөлтийг оруулснаар хоршоодын эрсдэл даах чадвар нэмэгдэж, мөн цар тахлын нөхцөл байдлын үед шаардлагатай мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар авснаар Санхүүгийн зохицуулах хорооноос тавих хяналтын чанарыг сайжруулах боломж бүрдсэн. Гэхдээ хөл хорионы үед санхүүгийн болон бусад тайлан мэдээллийг хуульд заасан хугацаанаас хожимдуулж ирүүлсэн цөөнгүй тохиолдол байгаа ч хүлээн авах хугацааны хувьд уян хатан хандсан.

Мөн хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурлыг 2020, 2021 онд цахим хэлбэрээр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцоог хангах зэргээр өөрийн хоршооны онцлогт тохируулан боломжтой хэлбэрээр зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн. Хоршоод ч хоёр дахь жилдээ тохиолдож буй нөхцөл байдалд цахим хурлыг илүү боловсронгуй хийж хэвшиж байгаа.

Цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар дурдаад яриагаа өндөрлөвөл?

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад УИХ-д өргөн барихад бэлэн болгоод байна. Мөн цахимжуулалтыг хурдтай хийх, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтад бүрэн шилжих ажлууд хийгдсээр байна. АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар журам, зааврыг шинэчлэх ажлууд хийгдэж байна.

Ярилцсанд баярлалаа.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ”

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 9 дүгээр сарын 08 –ны өдрийн 363 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталлаа.

Тус журмаар Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн

байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулна.

Дээрх журмын гол өөрчлөлтүүдийг дараах байдлаар үзүүлье:

1

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай харилцааг зохицуулсан бүлэг шинээр нэмэгдсэн;

2

Зуучлалын байгууллагаас ирүүлдэг комплайнсийн эрсдэлийн үнэлгээний тайлан, бизнесийн болон бүтцийн эрсдэлийн эрсдэлийн үнэлгээний тайланг ХШЗГ-ын мөнгө угаахтай тэмцэх албанаас авч эхэлсэн тул зохицуулалттай этгээдүүдээс ирүүлэх тайлан мэдээг давхардуулахгүйн тулд дээрх төрлийн тайланг хассан;

3

Зуучлалын байгууллагуудаас үндсэн үйл ажиллагааны сар бүрийн мэдээ тайланг бэлтгэх нь хүндрэлтэй байх тул улирал бүр дээрх тайланг тайлагнаж байх хүсэлтийг ирүүлсэн. Мөн Санхүүгийн зохицуулах хороо улирал бүр Санхүүгийн зах зээлийн тоймыг бэлтгэн олон нийтэд мэдээлдэг тул үндсэн үйл ажиллагаатай холбоотой сар бүрийн мэдээг улирал бүр тайлагнахаар өөрчлөлт оруулсан. Тайлангийн загварын хувьд зуучлалын байгууллагын хийсэн хэлцэл бүрээр дэлгэрэнгүй тайлагнахаар боловсруулсан тул тайлангийн агуулгад дээрх өөрчлөлт нөлөөлөхгүй;

4

Зуучлалын байгууллагаас сар бүр цаасаар болон цахимаар ирүүлдэг тайлан мэдээг улирал бүр цахимаар авахаар өөрчлөлт оруулж, тайлангийн агуулгыг дэлгэрүүлэх, тайлагналыг боловсронгуй болгож журмын хавсралтуудыг шинэчилсэн;

5

Иж бүрэн шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагаас гаргуулах тайлан мэдээ баримт бичгийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт ;

6

Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн сангийн журамтай нийцүүлэн зуучлалын байгууллагаас эхний хагас жилийн тайлан ирүүлэх хугацааг “7 дугаар сарын 20” гэснийг “7 дугаар сарын 10”, жилийн тайлан ирүүлэх хугацааг “02 дугаар сарын” гэснийг “01 дүгээр сарын 10” болгон өөрчлөлт тус тус оруулсан;

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН ДААТГАЛ

НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтод даатгалын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд нэгдэж ногоон даатгалын бүтээгдэхүүн санал болгох замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах хүрээ тэлэгдсээр байна.

Нөгөө талаасаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой учирч буй эрсдэлүүд нь даатгалын компаниудын зардлыг өсгөж байгаа тул даатгалын компаниуд тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах стратеги гарган ажиллах болсон.

Даатгалын компаниуд ногоон даатгалын бүтээгдэхүүнийг шинээр гаргаж даатгуулагчдын экологийн ул мөрийг багасгахад хувь нэмрээ оруулах болсон. Ногоон даатгал нь даатгуулагчийг эрсдэлд ороход нөхөн төлбөр олгон хамгаалахаас гадна байгаль орчинд ээлтэй орчныг бүрдүүлэхэд дэмжин хамгаалдаг даатгалын төрөл. Уг даатгал нь уламжлалт даатгалын системээс хураамжаасаа байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад хандив өгөх, даатгуулагчдыг байгаль орчинд ээлтэй, дахин ашиглаж болох материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах зэрэг хөшүүрэг ашигладгаараа ялгаатай.

Ногоон даатгалын төрлүүд:

Автотээврийн хэрэгслийн ногоон даатгал



Энэ төрлийн даатгал нь машинаараа хэдэн километр явснаасаа хамааран даатгалын хураамжаа төлдөг тул байгаль орчинд ээлтэй даатгалд хамаарна. Нийтийн тээврийн хэрэгслээр явах, ойрын зайнд алхах, дугуйгаар явах зэргээр машин унах хэрэглээгээ багасгах тусам төлөх хураамж буурдаг. Ингэснээр экологийн ул мөр багасах, хүлэмжийн хийн ялгарал буурснаар дэлхийн дулаарал удаашрах давуу талтай.

Бизнесийн ногоон даатгал



Бизнес эрхлэгчийн барилга чанаргүйдснээс үүдэлтэй дахин барих гэж байгаа нөхцөлд байгаль орчинд ээлтэй материалаар барихыг

хөшүүрэгдэх, түүнчлэн эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг ашиглах, ногоон материал ашигласан тавилга, эд хогшил худалдан авах, барилга бүрэн нурснаас үүдэлтэй байгаль орчинд ээлтэй стандартаар дахин барихыг сэдэлжүүлдэг даатгал. Барилга, байгууламж барихаас гадна байгаль орчинд ээлтэй оффистой байх хөшүүргийг мөн энэ төрлийн даатгалд ашигладаг. Тухайлбал, түлшээр ажилладаг машины оронд цахилгаан автомашин сонгох, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах зэрэг юм.

Байгаль орчинд ээлтэй орон байрны даатгал



Орон байр засварлахдаа байгаль орчинд сөрөг нөлөөтэй материал сонгохын оронд дахин боловсруулагдахуйц материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгслийг худалдан авах даатгал. Хэрэв аль хэдийнэ нарны эрчим хүч ашиглаж эхлээд, дахин боловсруулагдахуйц материал ашиглаж байгаа бол үүнд зориулсан нөхөн төлбөрийн даатгалыг мөн гаргасан. Тус даатгал нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдан авахад өндөр төлбөртэй нөхцөлд нөхөн төлбөр олгодог.

Аялал жуулчлалын ногоон даатгал



Та аялал зугаалгад явахдаа ч байгаль орчинд ээлтэй байх сонголтыг хийх боломжтой. Ялангуяа онгоцоор нисэх нь байгаль орчны доройтолд нөлөөлдөг. Байгаль орчинд ээлтэй аяллын даатгалаар дамжуулан экологийн ул мөрөө бууруулах боломжтой. Уг хураамжаас мөн адил ойжуулалтад хөрөнгө оруулдаг байна.

Ногоон урт хугацааны даатгал



Урт хугацааны даатгалын компаниуд нь даатгалын хураамжаас байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад хандив өгөх замаар даатгуулагчдынхаа экологийн ул мөрийг бууруулдаг.

Байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн даатгал




Эрүүл мэндийн даатгал шууд байгаль орчны асуудалтай холбогддоггүй ч хураамжаасаа ойжуулалт зэрэг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд хандивладаг.

Даатгалын салбарын тогтвортой хөгжлийг дэмжих өөр нэг арга нь хөрөнгийн зах зээлийн хувьд мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүрэгтэйгээр оролцдог тул хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Учир нь даатгалын салбарт 31.0 их наяд долларын нөөц сангийн

хөрөнгө хөрөнгө оруулалтад хийгддэг байна.

Даатгал нь мэргэжлийн хөрөнгө оруулагч талаасаа тогтвортой хөгжилд дараах байдлаар хувь нэмрээ оруулдаг:

- Хүртээмжтэй санхүүжилт, эрүүл мэнд
- Уур амьсгал болон байгалийн гамшигт уян хатан дэд бүтэц
- Тогтвортой хөдөө аж ахуй ба ойжуулалт
- Ногоон барилга, хүлэмжийн хийн бага эсвэл тэг ялгаралттай тээврийн хэрэгсэл
- Тогтвортой ус болон хог хаягдлын менежмент



СУДЛААЧИЙН ИНДЭР

ЯПОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

ХУРААНГУЙ

Азийн улс орнууд дундаас хамгийн түрүүнд эдийн засгийн хөгжлөөрөө хөгжсөн улс орнуудыг гүйцэж түрүүлэн, өдгөө Хятад, Тайланд, Мьянмар зэрэг Азийн бусад улсууд эдийн засгийн загварыг нь дуурайн галуун цуваа хэлбэрээр хөгжиж буй улсын жишээ бол Япон Улс юм. Манай улс ч тус улсын хөгжлийн загвараар замнан хөгжлийн гарцыг товчлох боломжтойг онцлон энэхүү судалгааны ажлаараа Япон улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийг судлахыг зорилоо.

Тус судалгаанд Япон улсын эдийн засаг хөгжихөд банкны

салбар, хөрөнгийн зах зээл, даатгал болон бичил санхүүгийн салбарын хэрхэн нөлөө үзүүлсэн, мөн мөнгөний болон сангийн бодлого нь үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөлсөн талаар агуулга багтсан.

Тус улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийг судлахдаа давуу болон сул талыг тодорхойлон Монгол улсын нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлж болох сайн туршлагауудыг судалгаандаа тусгаснаар онцлог гэж үзэж байна.

ТАНИЛЦУУЛГА

Япон Улсад анхны төр будааны тариалалт Вьетнамаас Хятадаар дамжин тариалагдаж эхэлснээр хүн хоорондын харилцаа нягтарч, нийгэм бий болсноор үүсэж байсан ба гаднын улс орны халдлагын нөлөөгөөр төр улс нь тогтворгүй болж улсынхаа хилийг 200 жилийн турш хааж байсан түүхтэй тус улс өдгөө Дэлхийн гуравдагч том эдийн засагтай улс болсон нь сонирхол татахуйц.

Хаалттай байсан 200 жилийг Эдо хааны үе гэж нэрлэдэг ба будааны тариалалт хөгжиж, түүнд суурилсан анхны фьючерсийн гэрээ Япон улсад үүсэж байсан. Түүнчлэн хаалттай хүрээнд эдийн засгаа дотооддоо хөгжүүлж, будааны тариалалт, нэхмэлийн үйлдвэрлэл, худалдаа зэрэг салбарууд хөгжсөн байдаг. Судлаачид Японы эдийн засгийг хурдан хөгжих суурь хүчин зүйлс болох боловсролын тогтолцоо энэ үед бүрдсэн гэж дүгнэдэг. Тухайн үед Хятад, энэтхэг улсуудтай хязгаартай хүрээнд харилцаж хөвөн, цай зэргийг импортолдог, бусад бараа, бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэдэг байв.

Япон улсын орчин үеийн эдийн засаг 1868 оноос АНУ болон Европын орнууд хилээ нээхийг шаардсанаар нээлттэй эдийн засгийн тогтолцоо руу шилжиж, барууны соёл маш хурдацтай нэвтэрснээр эхэлсэн. Хаалттай эдийн засгийн хүрээнд үндсэн сууриа бүрдүүлсэн тус улс АНУ болон Барууны орны хөгжлийн загвараас суралцаж, мөн импортын бараа, таваар ихээр худалдагдах болсон.

Энэхүү судалгааны ажилд Япон Улсын орчин үеийн буюу

1930 оноос өнөөг хүртэл эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжлийг хөгжсөн үе шат бүрээр нь судаллаа.

Нэгдүгээр бүлэгт Япон Улсын орчин үеийн эдийн засгийг 1945 оноос эхлэн өнөөг хүртэл хөгжлийн үе шатаар харуулсан ба дайны дараах уналтад орсон улс хэрхэн үсрэнгүй хөгжсөн түүх, хямарсан эдийн засгийг эргэн сэргээсэн, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад Засгийн газраас хэрэгжүүлсэн хөгжлийн бодлоготой танилцана.

Хоёрдугаар бүлгээс санхүүгийн зах зээлийг хяналт, зохицуулалт, крипто хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн зах зээл, даатгал, зээлийн батлан даалтын сан, банк болон бичил санхүүгийн салбарын хөгжил, тэдгээрийн санхүүгийн зуучлалын үүргээ гүйцэтгэсэн байдлыг эдийн засгийн хөгжлийн үе шаттай нь уялдуулж орууллаа.

Гуравдугаар бүлэгт мөнгөний болон сангийн бодлогын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад үзүүлсэн хариу үйлдэл юу байсан тухай туссан.

Дөрөвдүгээр бүлэгт 1970 оныг хүртэл санхүүгийн зах зээлийн хатуу зохицуулалтаас либералчлал хийж, санхүүгийн зах зээлд тавигддаг байсан хязгаарлалтууд буурсан талаар, тавдугаар бүлэгт дүгнэлтийг Япон Улсын сайн туршлагаас өөрийн улсад хэрэгжүүлж болох саналыг дэвшүүлсэн болно.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад хэрэгжүүлэхэд тулгамдах асуудал,
шийдвэрлэх арга замЯпон улсын туршлагаас Монгол Улсад
хэрэгжүүлэх арга хэмжээ

СЗХ–ны үйл ажиллагааны уялдаа холбоо, санхүүгийн салбарын үр ашгийг дээшлүүлэх	Орон нутаг дахь төлөөлөгчдөөр дамжуулан СЗХ–ны зохицуулалтын байгууллагуудад хяналт шалгалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх, хянан шалгагч эрх олгох, болон хүчинг чадваржуулах арга хэмжээ авах Мөн тэдгээрт хүрч ажиллаж, СЗХ–ноос гаргаж буй шийдвэрийг цаг алдалгүй авч, цаг тухай бүрт сургалт зөвлөгөө авах боломж бүрдэнэ.	СЗХ–ны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулан энэ талаар зохицуулалтыг тусгах шаардлагатай. СЗХ–ны орон нутгийн төлөөлөгч нь хавсарч ажил гүйцэтгэхгүй албан тушаалтан байх энэ талаар боловсон хүчний бүтцэд өөрчлөлт оруулах, төсөвт санхүүжилтийг тусгах.
	Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, биелэлтийг нийтэд ил болгож тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор бие даасан шинжээч авч дүгнүүлэх. Мөн санхүүгийн хэрэглэгчидтэй илүү ойр ажиллаж, тэдгээрийн санал хүслийг СЗХ–ны үйл ажиллагаанд тусгах үйл ажиллагааг эрчимжүүлэх эсхүл төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэгч агентлаг, холбоодоор дамжуулан хэрэгжүүлэх.	
	Улсын байцаагчийн зөвлөлийн ажиллах журам байдаг. Зөвлөлийн үүрэг хариуцлагыг өндөржүүлээд тогтмол үйл ажиллагаатай болгоход шийдвэрлэгдэнэ.	
	ЗЗСХГ нь салбарын эрсдэлийг бүхэлд нь харахдаа байгууллагын үйл ажиллагаа, мөнгө угаах, кибер аюулгүй байдал зэргийг том зургаар нь чухал авч үзэж СЗХ–ны шийдвэр гаргалтад нөлөөлөх. Мөн ХШЗГ, салбарын бодлогын газрын хоорондын уялдаа холбоог сайжруулах. Газар дээр хийгдсэн хяналт шалгалтаас нэгдсэн дүгнэлт гаргаж бодлогын баримт бичигт өгөх саналаа жил бүр бодлогын газарт хүргүүлдэг байх. Эндээс эрх зүйн орчинг сайжруулах бодит байдалд нийцсэн шийдлүүд гаргах нөхцөл бүрдэнэ.	
Санхүүгийн салбарын хүнд суртлыг бууруулах	Монгол улс дахь аудитын байгууллагын үйл ажиллагаа нь бүхий л салбарын байгууллагуудад аудит хийх байдлаар өргөн хүрээг хамардаг тул салбарт бүрт нарийвчилсан аудит хийхдээ тухайн салбарын зохицуулагч байгууллагаас давхар зөвшөөрөл авахаар зохицуулагдсан байна. Энэ давхардлыг арилгахын тулд боломжтой бол давхар зөвшөөрөл авахгүйгээр нэгдсэн байдлаар зохицуулах нь үр ашигтай. Мөн аудитлагдсан тайланд эргэж хариуцлага тооцох механизмыг бий болгох шаардлагатай. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагуудад аудит хийх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай.	
	Монгол Улсын хууль эрх зүйн орчны онцлогоос шалтгаалан хууль батлахдаа заавал дүрэм, журмыг дагаж гаргадаг. СЗХ–ны хувьд эрх зүйн байдлын тухай хуулиар эрх олгодоогүй тул өөрөө хууль санаачлах, батлуулах эрх хомс байгаа нь салбарын хуулийн шинэчлэлтийг цаг алдалгүй хийхэд саад учруулж байна. Иймд эрх зүйн байдлын тухай хуулийг яаралтай өөрчлөн, салбарт бүрт шинэчилсэн найруулгын хуулийг боловсруулахдаа заавал дагаж мөрдөх олон дүрэм, журамгүйгээр том хуулийг боловсруулах хэрэгтэй.	Цаг хугацаа их шаардана.
Санхүүгийн салбарын оролцогчдын чадавхыг сайжруулах	Зөвхөн хатуу дүрмээр зохицуулах бус сайн дураар хэрэгжүүлэх боломжтой зарчмыг зааж өгснөөр илүү сайн зохицуулалтыг цогцлооно.	
	Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг батлан нийтлэх. Санхүүгийн зах зээлд оролцогчдын ёс зүйн зарчмыг тогтоох.	
СЗХ–ны хүний нөөцийг сайжруулах	Боловсон хүчнийхээ чанарыг сайжруулах, ажиллагсдаа мэргэжлийн чиглэлд сургалт орж улам нөөц бололцоогоо нэмэгдүүлэх. Технологийн мэдлэгтэй мэргэшсэн боловсон хүчнийг нэмэгдүүлэх.	
СЗХ–ны цахим хуудсыг сайжруулах	Бодлогын баримт бичиг, шаардлагатай чухал мэдээллийг мэдээ, мэдээлэл цэснээс тусад нь салбар бүрээр гарчиглан оруулах шинэ цэстэй болох.	Тулгамдах асуудал байхгүй.
	Түгээмэл асуулт, хариултын цэстэй болох. Ихэвчлэн бүртгэлийн чиглэлийн асуудлыг салбар бүрээр маш дэлгэрэнгүй байдлаар хариулж бичих.	Тулгамдах асуудал байхгүй.

ЭХ СУРВАЛЖ

- Vittorio Vally. "Growth and crisis in the Japanese economy". 2012
- Kenichi Ohno. "The Economic Development of Japan". GRIPS Development Forum. 2006
- Masahiro Takada. "Japan's Economic Miracle: Underlying Factors and Strategies for the Growth". 1999
- Okazaki Tetsuji. "Lessons from the Japanese Miracle". 2015
- Nakamura Takafusa. "Rapid Growth: The Postwar Japanese Economy: Its Development and Structure".
- Liu Haoyuan. "Japanese and Germany Postwar Economic Miracle". Finance world. 2010
- Naoki Abe. "Japan's Shrinking Economy". Brookings. 2010
- Н.Нарантуяа. "Япон улсын санхүүгийн зах зээлийн хөгжил". 2020
- Э.Хонгорзул. "Япон орны хөгжлийн түүх". 2016
- Д.Санчир. "Хөгжлийн гайхамшиг цуврал: Япон". 2016
- Adrienne Sala. "The Japanese Consumer Finance Market and its Institutional Changes since the 1980s". *"INCAS Discussion paper series"*, 03, 2019
<https://halshs.archives-ouvertes.fr/halshs-02088335/document>
- Aoki Masaru. "Japan to Scrap "Gray Zone" lending rates". *"Japan SPOTLIGHT"*, January/February 2007.
https://www.ief.or.jp/journal/pdf/finance_0701.pdf
- Arthur J.Alexander, Kong Dan Oh. "The Development and Structure of Consumer Credit in Japan". *"The RAND Publication Series"*, N-2902, 1989.
<https://apps.dtic.mil/dtic/tr/fulltext/u2/a228097.pdf>
- Japan Federation of Credit Guarantee Corporations. *Credit Guarantee System in Japan*, 2020.
https://www.zenshinoren.or.jp/document/Credit_Guarantee_System_in_Japan_2020.pdf
- Roohollah, A. Alireza, D., Asian Development Bank Institute. *The role of credit guarantee schemes in the development of small and medium-sized enterprises with an emphasis on knowledge-based enterprises*, 2019.
<https://www.adb.org/sites/default/files/publication/490511/adbi-wp930.pdf>
- Le Ngoc Dang, Anh Tu Chuc, Asian Development Bank Institute. *Challenges in implementing the credit guarantee scheme for small and medium-sized enterprises: the case of Vietnam*, 2019
<https://www.adb.org/sites/default/files/publication/496271/adbi-wp941.pdf>
- Зээлийн батлан даалтын сангийн цахим хуудас
<https://www.lqi.mn/>
- Шилэн дансны цахим хуудас
<https://shilendans.gov.mn/>
- Санхүүгийн зохицуулах хороо. *Санхүүгийн зах зээлийн тойм 2020 он*, 2020
<http://www.frc.mn/resource/frc/Document/2021/03/23/fgs6as5bg1v7v5ea/foim%202020%20last.pdf>
- Swiss Re Corporate History, A History of Insurance in Japan, 2017, 8022 Zurich Switzerland
https://www.swissre.com/dam/jcr:5d8ab068-69ae-4a92-9672-0037ad56150a/150Y_Markt_Broschuere_Japan_Inhalt_Red.pdf
- Shinichi Takahashi, Masashi Ueda and Takumi Takagi, Nishimura and Asahi, Thomson Reuters Practical Law, "Insurance and reinsurance in Japan: overview", 2021.
https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-501-31632?transitionType=Default&contextData=sc.Default&firstPage=true&co_anchor_a110629
- The Toa Reinsurance Company, Limited, Japan's insurance market 2020, Kanda-Surugadai 3-chome, Chiyoda-ku, Tokyo 101-8703, Japan
https://www.toare.co.jp/english/img/knowledge/pdf/2020_insurance.pdf
- Ernst & Young Global Limited, 2020 Japan insurance outlook, EYG no. 005354-19Gb1, 2019 EYGM Limited.
https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/en_gl/topics/insurance/insurance-outlook-pdfs/ey-global-insurance-outlook-japan.pdf
- Санхүүгийн зохицуулах хороо. *Санхүүгийн зах зээлийн тойм 2020 он*, 2020
<http://www.frc.mn/resource/frc/Document/2021/03/23/fgs6as5bg1v7v5ea/foim%202020%20last.pdf>
- Shinkin Central Bank, "Annual report 2020", 2020
https://www.shinkin-central-bank.jp/es/financial/pdf/all_2020.pdf
- Akira Kurimoto, "Rokin Banks: 70 years of efforts to build an inclusive society in Japan through enhancing workers' access to finance", Takashi Koseki, Valerie Breda, International Labour Organization, 2019
https://www.ilo.org/wcmsp5/groups/public/-/ed_emp/documents/publication/wcms_695734.pdf
- Takeo Hoshi, "What happened to Japanese banks?", "Monetary and Economic studies", 2001
<https://www.imes.boj.or.jp/research/papers/english/me19-1-1.pdf>
- Deposit Insurance Corporation of Japan, "Annual Report 2019/2020", 2020
<https://www.dic.go.jp/content/000028609.pdf>
- Asakura, K.Ichichi. "the characteristics of finance in the meiji period (the period of take off)." *The Developing Economies* 5.2 (1967): 274-299.
<https://online.library.wiley.com/doi/pdf/10.1111/j.1746-1049.1967.tb00500.x>
- Hoshi, Takeo, and Anil Kashyap. *Corporate financing and governance in Japan: The road to the future*. MIT press, 2004.
- Miwa, Yoshio, and J. Mark Ramseyer. "Banks and economic growth: implications from Japanese history." *The Journal of Law and Economics* 45.1 (2002): 127-164
<http://www.law.harvard.edu/faculty/ramsever/1/banksandecon.pdf>
- Patrick, Hugh T. "Japan's financial system and the evolving role of main banks." (1991)
- Shizume, Masato, and Masayoshi Tsurumi. *Modernizing the financial system in Japan during the 19th century: National Banks in Japan in the Context of Free Banking*. No. 1607. 2016.
https://www.waseda.jp/fse/winpec/assets/uploads/2016/09/No.E1607Shizume_Tsurumi.pdf
- PWC. *Survival and success: Securing the future for Japanese banks*, 2014
<https://www.pwc.com/gx/en/banking-capital-markets/assets/pwc-future-of-japanese-banking-final-march-2014.pdf>
- Global financial centres index, 26 March 2020,
<https://www.zvsn.com/news/press-releases/press-release-global-financial-centres-index-27/>
<https://www.boj.or.jp/en/pavm/market/data/market1811.pdf>
- Shizume, Masato. *Historical Evolution of Monetary Policy (Goals and Instruments) in Japan: From the Central Bank of an Emerging Economy to the Central Bank of a Mature Economy*. No. E1803. WINPEC Working Paper Series, 2018.
<https://www.waseda.jp/fse/winpec/assets/uploads/2014/05/No.E1803.pdf>
- Jinushi, Toshiki, Yoshihiro Kuroki, and Ryuzo Miyao. "Monetary policy in Japan since the late 1980s: delayed policy actions and some explanations." *Japan's financial crisis and its parallels to US experience* (2000): 115-48.
https://www.niie.com/publications/chapters_preview/319/6ie289X.pdf
- Yoshino, Naoyuki, and Farhad Taghizadeh-Hesary. "Effectiveness of the easing of monetary policy in the Japanese economy, incorporating energy prices." *Journal of Comparative Asian Development* 14.2 (2015): 227-248.
<https://www.waseda.jp/fse/winpec/assets/uploads/2014/05/No.E1803.pdf>
- Effectiveness of the Easing of Monetary Policy in the Japanese Economy. *Incorporating Energy Prices* (adb.org)
- Takeda, Masahiro, and Philip Turner. "The liberalisation of Japan's financial markets: some major themes." (1992).
<https://www.bis.org/publ/econ34.pdf>
- Savage, J.D. (2002-06-01). *"The Origins of Budgetary Preferences: The Dodge Line and the Balanced Budget Norm in Japan"* (PDF). *Administration & Society*.
<https://www.jstor.org/stable/2975501?seq=1>
- A history of Public finance, Tokyo 1941
- Statistical Yearbook of Finance and Economy of Japan, Part I, Public Finance, Ministry of Finance and Bank of Japan 1948, pp. 9-254
- Japan's Economy in War and Reconstruction, University of Minnesota Press, pp.85-93
- Alesina, A. and R. Perotti, 1995, Fiscal expansions and adjustments in OECD countries, *Economic Policy* vol.21, pp.207-248.
- Alesina, A. and R. Perotti, 1996, Fiscal adjustments in OECD countries composition and macroeconomic effects, National Bureau of Economic Research Working Paper No.5730.
- Alesina, A. and G. Tabellini, 1990, A positive theory of fiscal deficits and government debt, *Review of Economic Studies* vol.57, pp.403-414.
- Asako, K., T. Ito, and K. Sakamoto, 1991, The rise and fall of the deficit in Japan, *Journal of the Japanese and International Economies* vol.5, pp.451-472.
- Doi, T. and T. Ihori, 2002, Fiscal reconstruction and local interest groups in Japan, *Journal of the Japanese and International Economies* vol.16, no.4, pp.492-511.
- Ihori, T., T. Doi, and H. Kondo, 2001, Japanese fiscal reform: fiscal reconstruction and fiscal policy, *Japan and the World Economy*, vol.13, issue 4, pp.351-370.
- Ihori, T. and H. Kondo, 2001, Efficiency of disaggregate public capital provision in Japan, *Public Finance and Management* vol.1, pp.161-182.
- Ihori, T., T. Nakazato, and M. Kawade, 2003, Japan's Fiscal Policies in the 1990s, *The World Economy* 26, 325-338.
- Persson, T. and L.E.O. Svensson, 1989, Why stubborn conservative would run a deficit: Policy with time-inconsistent preferences, *Quarterly Journal of Economics* vol.104, pp.325-345.
<http://www.fordschool.umich.edu/rsie/Conferences/CGP/May2004PreconfPapers/Ihori.pdf>
https://www.mof.go.jp/pri/research/seminar/ty2017/tff2017_S3P1.pdf
<https://www.oecd.org/gov/budgeting/budgeting-and-public-expenditures-2019-japan.pdf>
<https://www5.cao.go.jp/keizai1/mitoshi/2020/r030118mitoshi-e.pdf>
- Cooney, Kevin J. *Japan's Foreign Policy Since 1945* (2006)
- Hook, Glenn D. et al. *Japan's Foreign Policy: Politics, Economics and Security* (2011) excerpt and text search
- Inoguchi, Takashi. *Japan's foreign policy in an era of global change* (A&C Black, 2013)
- Langdon, Frank. *Japan's foreign policy* (U. British Columbia Press, 2011)
- Maslow, Sebastian, Ra Mason and Paul O'Shea, eds. *Risk State: Japan's Foreign Policy In An Age Of Uncertainty* (Ashgate. 2015) 202pp excerpt
- Scalapino, Robert A., and Edwin O. Reischauer, eds. *The Foreign Policy of Modern Japan* (1977)
- Amsden, A. (1989). *Asia's next giant: South Korea and late industrialization*. New York: Oxford University Press.
- Amyx, J. (2004). *Japan's financial crisis: Institutional rigidity and reluctant change*. New Jersey: Princeton University Press.
- Aoki, M., Kim, H.K., & Fujiwara, M.O. (Eds.). (1997). *The role of government in East Asian economic development: Comparative institutional analysis*. Oxford and Tokyo: Oxford University Press and Clarendon Press.
- Aronson, B. (2011). *Japan's big bang program: Did 20 years of financial regulatory reform really fail?* East Asia Forum Quarterly, 3(1), Retrieved from: <http://eprints.anu.edu.au/wp-content/uploads/2011/07/whole.pdf>
- Maichichi Shimbun, April 20, 2012.
- Borton, Hugh (January 1948). "American Occupation Policies in Japan". *The Academy of Political Science*. 22: 37-44. JSTOR 1172867.
- Sumiya, Mikio (1994). *A History of Japanese Trade and Industry Policy*. Oxford University: Oxford University Press.
- Japan cuts view of Jan. exports as U.S.-China spat hurts trade, Asahi Shimbun
- "Japan's trade deficit first since", January 25, 2012.
- Bhagwati, J. (1988) *Protectionism*, The MIT Press, Cambridge, Massachusetts ISBN 0-262-52150-4
- Dick, A. (1995) *Industrial Policy and Semiconductors: Missing the Target*, AEI Press, Washington, D.C. ISBN 0-8447-7043-4
- Greaney, T. (1996) "Import Now! An Analysis of Market-share Voluntary Import Expansions (VIEs)", *Journal of International Economics* 40 149-163.
- Parsons, C. (2002) "Did the US-Japan Semiconductor Trade Agreement Have any Impact?" *Asian Economic Journal* 16(1) 37-51.DOI: 10.1111/1467-8381.00141
- Japanese-US Economic Relations from the Dean Peter Krogh Foreign Affairs Digital Archives
- Mitsuhiro Fukao. *Capital account liberalisation: the Japanese experience and implications for China*, 2003.
- Masahiko Takeda, Philip Turner. *The liberalization of Japan's financial markets: Some Major Themes*. 1992

ХАВСРАЛТ

Крипто хөрөнгийн талаарх дагалдах дүрэм, журмууд (Япон хэл дээр)

Business handling relationship

Rules regarding crypto-assets handled related to derivatives

Blockchain asset-related derivative transactions rules

Rules for managing and explaining customers related to crypto asset-related derivative trading

Rules for creating an order management systems for blockchain asset-related derivative trading

Rules for preventing unfair trade related to crypto asset-related derivative trading operations

Rules for establishing a management system for blockchain asset-related info for blockchain asset-related derivative trading operations

Customer property management, system safety management, etc.

Rules for managing customer property related to crypto asset-related derivative trading operations

Rules for system risk management related to crypto asset-related derivative trading operations

Rules for emergency response related to crypto asset-related derivative trading operations

Rules for security management of information related to crypto asset-related derivative trading operations

Solicitation / Advertising

Rules regarding solicitation and advertising related to crypto asset-related derivative trading business

AML / CFT / antisocial forces

Rules for AML & CFT measures related to crypto asset-related derivative trading business

Rules for stopping client relationships with antisocial forces related to crypto asset-related derivative trading business

Accident confirmation application

Rules for confirmation application and examination of accidents related to crypto asset-related derivative trading operations

Complaint / dispute resolution

Rules on disputes mediation related to blockchain asset-related derivative trading operations

Financial product intermediary

Rules for financial instruments brokers

Employee service

Rules regarding the services of employees etc. for crypto asset-related derivative trading operations

Sales representative registration, etc.

Rules on the registration of sales representatives, etc.

Detailed rules regarding the registration of sales representatives.

System for conducting the sales representative qualification test

ХУРИМТЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хуримтлал гэдэг нь: Богино, дунд, урт хугацааны хэрэгцээгээ хангах зорилгоор хуримтлуулж буй мөнгө, үнэт цаас болон бусад хөрөнгийг хэлнэ.



Хуримтлал
үүсгэхийн тулд

1

Санхүүгийн зорилгоо
тодорхойлно

2

Хуримтлал үүсгэх орлогын эх үүсвэрээ
төлөвлөнө /цалин, бусад гэх мэт.../

3

Мөнгөний хэрэгцээт
хугацааг төлөвлөнө

4

Хуримтлал өсгөх боломжуудыг
судална



Давуу тал



1. Санхүүгийн дарамтаас
хамгаална



2. Нэмэлт орлого олно
/хүүгийн орлого/

Сул тал




1. Өндөр инфляциас
шалтгаалж үнэ цэнэ буурах
эрсдэлтэй



2. Хэрэглээ
танагдана

ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ АЛХМУУД



ХЭРЭГЛЭГЧ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ЦАР ТАХЛЫН ҮЕД ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АЖЛУУД

2021.09.30–ны өдрийн байдлаар


Хяналт шалгалт, зөвшөөрөл олголт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

Санхүүгийн зохицуулах хороо 2021 оны 1 дүгээр улиралд нийт 5,700 гаруй санхүүгийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг бөгөөд 2020 оны 4 дүгээр сарын 06–ны өдрөөс эхлэн холбогдох өргөдөл, хүсэлтийг цахим <https://license.frc.mn/home/онлайн/>–аар хүлээн авч шийдвэрлэж байна. Ингэснээр дээрх 5,700 гаруй иргэн, хуулийн этгээдэд гадна бусад иргэн, хуулийн этгээд Санхүүгийн зохицуулах хорооны бүхий л төрлийн үйлчилгээг цахимаар авах бүрэн боломжтой болоод үйл ажиллагаа бүхэлдээ цахим горимоор хэвийн ажиллаж байна.

УИХ–аас баталсан Коронавируст халдвар /КОВИД–19/–ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон 2020 оны 11 дүгээр сарын 18–ны өдрийн Засгийн газрын 183 тоот тогтоол батлагдаж, Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/, Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/–ны зээлийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгжүүдэд зээлийн дарамт үүсгэхгүй, төлбөрийн чадварт нь нийцсэн байдлаар зээлийн төлбөрийг сунгах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос тодорхой ажлууд хийсэн. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 11 дүгээр сарын 19–ний өдрийн 3/4654 тоот албан бичгээр зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт **495 ББСБ руу мэдэгдэл хүргүүлсэн**. Үүнээс 2020 оны 11 дүгээр сарын 22–ны өдрийн байдлаар 447 ББСБ–тай утсаар холбогдож, мэдэгдлийг хүлээж авсан, түүний дагуу ажиллах талаар мөн үүрэг өгсөн. Ихэнх ББСБ–ууд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг эерэгээр хүлээн авч, үйл ажиллагаагаа явуулж байгаа уг шийдвэрийн дагуу нэмэгдүүлсэн хүү, алданги, анз зэргийг бодохгүй байгаа, одоогийн байдлаар цахим хэлбэрээр, утсаар холбогдож зээлийн гэрээг сунгах хүсэлтийг авч байгаагаа тус тус мэдэгдсэн. Мөн 2020 оны 11 дүгээр сарын 23–ны өдөр Хороо өөрийн цахим хуудсаар дамжуулан ББСБ–ын нийт **зээлдэгчдэд хандан** [/http://www.frc.mn/a/3445/](http://www.frc.mn/a/3445/) мэдэгдэл гаргасан бөгөөд зээлдэгч зээлээ хойшлуулах хүсэлтээ гаргах, хэрэв тухайн ББСБ нь шийдвэрлэхгүй байгаа бол холбогдох гомдлоо Санхүүгийн зохицуулах хорооны тусгай утас болон цахим хэлбэрээр хандан шийдвэрлүүлэх боломжтой талаар дурдсан.

Тайлант 2021 оны хувьд Ковид цар тахлын үед бүх нийтийн хөл хориотой үе буюу 2020 оны жилийн эцсийн тайлан, мэдээг хэрхэн ирүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 08–ны өдрийн албан мэдэгдлийг бүх ББСБ–д цахимаар хүргэсэн. Түүнчлэн Ковид –19 цар тахлаас үүдсэн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор Монголбанкны Зээлийн мэдээллийн санд тохируулга хийх тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийн талаарх мэдээллийг /2021.6.30/ бүх ББСБ–д цахимаар хүргэн ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас [/http://www.frc.mn/i/Feedback/](http://www.frc.mn/i/Feedback/)–аар болон 51–262608, 51–261275 дугаарын утсаар хүсэлт, гомдлыг хүлээн авч эхэлсэн. 2021 оны 9 дүгээр сарын 30–ны өдрийн байдлаар албан бичгээр нийт 338 өргөдөл, гомдол хүлээн авч 91 хувийг буюу 309 өргөдлийг шийдвэрлэсэн, 29 өргөдөл хянагдаж байна. Нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 19.0 хувийг ББСБ, 3.0 хувийг ХЗХ, 29.6 хувийг үнэт цаас, 45.9 хувийг даатгалын үйл ажиллагаатай хамаарал бүхий асуудал өргөдөл эзэлж байна. Дээрх өдрийн байдлаар цахимаар 121 өргөдөл гомдол ирүүлсэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, ХЗХ–ны бүх гишүүдийн ээлжит хурлыг хуралдуулахад хүндрэлтэй байдал үүссэн тул нэг дор олон хүн цуглуулахгүйгээр хурлыг цахим хэрэгсэл, зайны технологийг ашиглан зохион байгуулах чиглэлийг Санхүүгийн зохицуулах хорооноос өгснөөр хувьцаат компани, ХЗХ–д хэлэлцвэл зохих асуудлуудаа бүрэн шийдвэрлэсэн байна. 2021 оны 9 дүгээр сарын 30–ны өдрийн байдлаар 159 хувьцаат компани, 160 ХЗХ–д бүх гишүүдийн хурлаа цахимаар хуралдсан байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГТ АНХААРАЛ ХАНДУУЛАХ НЬ

Бизнесийг хэрхэн удирдаж, засаглах, үүний нийгэмд үзүүлэх нөлөө нь улам бүр нэмэгдэж байна. Мэдээж Ковид-19 цар тахал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн бөгөөд цар тахлын үр нөлөө, урт хугацааны үр дагаварт Засгийн газар, компани, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талууд хариу үйлдэл үзүүлсээр байна. Үүнтэй зэрэгцэн сүүлийн жилүүдэд Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (ESG) асуудлууд хүчээ авч байгаатай холбоотойгоор компанийн үүрэг роль, зорилгын талаар шинээр мэтгэлцээн, хэлэлцүүлгүүд өрнөж байна.

Ковид-19: цахим шилжилт ба урт хугацааны нөлөөлөл

Ковид-19 цар тахлын компанийн засаглалын бүтэц, үйл явц, анхаарах асуудалд үзүүлэх нөлөө нь цахим засаглалд шилжих зайлшгүй хэрэгцээг үүсгэсэн ба энэ нөлөөлөл агшин зуур өрнөсөн тул маш богино хугацаанд дасан зохицох шаардлагатай болсон.

ТУЗ-ийн цахим хурал

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал цахим хэлбэрт шилжих нь зарим байгууллагын хувьд ердийн зүйл биш байсан тул үр дүнтэй хурлыг хэрхэн зохион байгуулах тухай асуудал сөхөгдөж байна. Цахимаар үр дүнтэй уулзалтыг зохион байгуулах нь технологийн бэрхшээл, цагийн бүс, хувийн ажлын зохион байгуулалт зэрэг асуудлыг амжилттай шийдвэрлэхээс гадна уулзалтын хэлбэр, зохион байгуулалтыг хэрхэн виртуал форматад уялдуулан зохицуулах явдал аж. Ковид-19 цар тахал бизнесийн бүх шатны удирдлагуудыг заавал биечлэн уулзалгүйгээр удирдах, засаглах чадвартай болоход нь тусалсан.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотойгоор дэлхийн улс орнуудын Засгийн газрууд, зохицуулагч байгууллагууд өөр өөр арга барилаар хандаж байв. Шийдэл нь хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох хууль ёсны эрхийг

хязгаарлахаас эхлээд хурлыг "хаалттай хаалганы цаана" зохион байгуулах, эсвэл хувьцаа эзэмшигчид хуралд биечлэн оролцож буйтай ижил төстэй байдлаар эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгодог цахим хурлын хэлбэр зэрэг багтсан.

Удаан хугацаанд хэрэгжих өөрчлөлтүүд


Компаниуд болон засаглалын мэргэжилтнүүд сүүлийн 18 сарын хугацаанд хийсэн дасан зохицол, өөрчлөлтүүдийн аль нь цаашид засаглалын тогтолцооны байнгын хэв шинж, чанар болон үлдэх вэ гэдгийг эргэцүүлж байна. Ихэнх компанийн гүйцэтгэх удирдлагууд нүүр тулсан уулзалт, газар дээр нь очиж үзэхийн ач холбогдлын талаар маргахгүй бөгөөд цар тахлын өмнө олон компаниуд цахим хэлбэрийн хурлын үр дүнд эргэлзэж байсан байх. Гэсэн хэдий ч цахим хурал харьцангуй амжилттай хэрэгжсэн бөгөөд цаг, зардлыг бууруулах, цахим санал тооллогын хувьд хурд, баталгаа зэрэг нь давуу тал болжээ.

Өмнө нь хувьцаа эзэмшигчдийн цахим хурлыг зөвшөөрөөгүй байсан зарим улс орнууд хууль эрх зүйн болон зохицуулалтын байнгын болон түр зуурын өөрчлөлтийг оруулсан бөгөөд цахим харилцааны цаашдын хэрэглээ үргэлжлэх бололтой.

Төрийн оролцоо

Коронавируст цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орны Засгийн газрууд бизнесийн орчинг сайжруулах үүднээс нийгэм, эдийн засгийн сөрөг арга хэмжээг авч байгаа нь цаашид төр, бизнесийн харилцааны хандлагад өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй.

Учир нь бизнесийн өрсөлдөх чадвар, оршин тогтнолыг дэмжихийн тулд одоо мөрдөж буй хууль, дүрэм, журмаар тавигдсан шаардлагуудыг түр, эсвэл бүр мөсөн сулруулах зэрэг шийдлүүд ирэх он жилүүдэд компанийн засаглалын дүр төрхийг цоо шинээр өөрчлөх шинэ үе рүү хөтлөх нь зайлшгүй.



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Монголын Банкны холбооноос банкны өрсөлдөх чадварын судалгааг танилцуулав.

Банкны өрсөлдөх чадварын судалгаанд нийт 39 улсыг түүврийн аргаар сонгосон ба тэдний 22 нь уул уурхайн салбараас хамааралтай улсууд байсан бол 15 нь орлогын түвшний хувьд Монгол Улстай ойролцоо байв. Судалгааны үр дүнд Саудын Араб тэргүүлж, Австрали улс удаалсан бол Африкийн орнууд доогуур жагссан байна. Манай орны хувьд 26 дугаар байранд жагсаж, дунджаас доогуур гэсэн үнэлгээ авсан ба уул уурхайн салбараас хамааралтай 22 улсаас 15 дугаар байранд, ойролцоо түвшний орлоготой 15 улсаас 6 дугаар байранд тус тус жагсжээ.

Япон Улсын эдийн засаг 1.9 хувиар өсөв.

Ази тивийн хоёр дахь том эдийн засагтай Япон Улсын ДНБ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өслөө. Ковид-19-ийн тархалт эрчимжиж, Ерөнхий сайд нь огцрохоо мэдэгдээд байгаа энэ үед эдийн засгийн өсөлт нь шинжээчдийн таамгаас өндөр байна. Шинжээчид 1.6 хувиар, харин тус улсын Засгийн газар 1.3 хувиар өснө гэж тооцоолж байжээ. Компаниудын хөрөнгийн зарцуулалт, өрхийн хэрэглээ, Засгийн газрын нэмэлт төсвийн зарцуулалт өндөр байсан нь үүнд голлон нөлөөлсөн байна. Хэдийгээр халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа ч Олимпын наадам нь компани, худалдан авагчдын зарцуулалтад гол түлхэц болжээ.

БНХАУ Бээжинд хөрөнгийн бирж байгуулна.

Хятадын эрх баригчид нийслэл Бээжин хотдоо шинэ хөрөнгийн бирж байгуулахаар төлөвлөж байна. Энэ тухай БНХАУ-ын ерөнхийлөгч Ши Жиньпин 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр нээгдсэн Хятадын олон улсын үйлчилгээний худалдааны үзэсгэлэнд дүрс бичлэгээр үг хэлэхдээ мэдэгджээ. "Бид жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновацийн хөгжлийг үргэлжлүүлэн дэмжиж, шинэ биржээс гадуурх үнэт цаасны зах зээлийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхийн сацуу Бээжинд хөрөнгийн бирж байгуулж, шинэлэг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үйлчлэх томоохон тавцан байгуулна" гэж тэрбээр цохон тэмдэглэсэн байна.

Хятад улсын хөрөнгийн гол биржүүд Шанхай, Шэньжэн, Хонконгт байрладаг. Үүнээс гадна, Далянь, Жэнжоу, Шанхай зэрэг хэд хэдэн хотод түүхий эдийн биржтэй. Хятадын олон улсын үйлчилгээний худалдааны үзэсгэлэн бол энэ салбартаа дэлхийн хамгийн том үзэсгэлэн юм.

БНХАУ-ын экспорт 8 дугаар сард 25.6 хувиар өсөж, \$294.3 тэрбум хүрэв.

БНХАУ-ын экспорт өмнөх оны мөн үеэс 25.6 хувиар өсөж, \$294.3 тэрбум хүрсэн нь шинэ дээд үзүүлэлтийг тогтоолоо. Худалдааны тэнцлийн хувьд \$58.3 тэрбум ашигтай гарсан талаар тус улсын Гаалийн удирдлагын газар мэдээлсэн. Тус улсын хамгийн ачаалалтай байдаг Нинбо боомт 8 дугаар сард 14 хоног ажиллаагүй ч өндөр үзүүлэлттэй байсныг тодотгосон байна. Хэдий тийм боловч олон улсад, ялангуяа АНУ болон Европт эрэлт өндөр байгаа нь экспорт өсөхөд голлон нөлөөлжээ. Талархлын баяр болон Зул сарын баяр ойртож байгаа энэ үед улирлын шинж чанартай холбоотойгоор 11 дүгээр сар хүртэл эрэлт өндөр байх төлөвтэй байна. Түүнчлэн БНХАУ-ын худалдааны гол түншүүд болох Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоо /АСЕАН/, Европын Холбоо, АНУ-тай хийсэн гадаад худалдааны хэмжээ 2021 оны эхний 8 сарын хугацаанд тогтвортой өсөлтөө хадгалсан хэвээр байна.

Австралийн Төв банк бонд худалдан авалтаа бууруулж, бодлогын хүүгээ 0.1 хувьд хадгалав.

Австралийн Төв банк бонд худалдан авах хэмжээгээ нэг тэрбумаар бууруулж, долоо хоногт \$3 тэрбум бонд худалдан авна гэж мэдээллээ. Харин бодлогын хүүгээ 0.1 хувьд хэвээр үлдээхээр болсон байна. Тус улсад "Дельта" хувилбарын тархалт өндөр байгаа тул бонд худалдан авалтаа бууруулахгүй гэж шинжээчид тооцоолж байсан юм.

Эдийн засгийнх нь ихээхэн хэсгийг бүрдүүлдэг Сидней болон Мельбурн хотод хатуу хөл хорио тогтоосны улмаас өрхийн зарцуулалт 15 хувиар буурна гэж Австралийн Төв банк тооцоолж байна. 2021 оны 7 дугаар сард ажилгүйдлийн түвшин нь 4.6 хувь болсноор 2008 оноос хойших түүхэн доод түвшинд хүрлээ.

АНУ–ын нефтийн үнэ өсжээ.

АНУ–ын нефтийн нөөц буурсан тухай мэдээлэл гарсны дараа нефтийн үнэ 2021 оны 9 дүгээр сарын 2–ны өдөр өсжээ. Тодруулбал, Нью–Йоркийн биржид “WTI” маркийн нэг торх нефтийн 10 дугаар сард нийлүүлэх фьючерс хэлцлийн үнэ 1.40 ам.доллараар өсөж, 69.99 ам.долларт хүрчээ. Мөн “Brent” маркийн нефтийн 11 дүгээр сард нийлүүлэх үнэ 1.44 ам.доллараар өсөж, 73.03 ам.долларт хүрсэн байна.

Нефтийн үнэ ийнхүү өсөхөд АНУ–ын нефтийн нөөц буурсан талаарх мэдээлэл нөлөө үзүүлжээ. АНУ–ын Эрчим хүчний мэдээллийн агентлагаас /EIA/ 9 дүгээр сарын 3–ны өдөр мэдээлснээр, улсын нефтийн нөөц 8 дугаар сарын 27 –ны өдөр хүртэлх долоо хоногт 7.2 сая торхоор буурсан байна. Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт бензиний нөөц 1.3 сая торхоор, нэрмэл түлшний нөөц 1.7 сая торхоор тус тус буурчээ. Үүнтэй зэрэгцэн худалдаачид нефть олборлогч томоохон орнуудын олборлолтын бодлогын талаарх шийдвэрийг үргэлжлүүлэн дагахаар болоод байна.

9 дүгээр сарын 1–ний өдөр Нефть экспортлогч орнуудын байгууллагын гишүүд болон түүний холбоотнууд /ОПЕК+/ өдөрт олборлох нефтийн хэмжээгээ сар тутам 400 мянган торхоор үргэлжлүүлэн нэмэгдүүлэхээр тохиролцсон юм.

АНУ Украинд гурван тэрбум ам.долларын тусламж үзүүлнэ.

АНУ–ын Экспорт–Импортын банк (Эксимбанк) харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсны дараа Украинд \$3 тэрбум тусламж үзүүлэхээр болжээ. АНУ–ын Эксимбанк нь үндэсний бизнес эрхлэгчдийг гадаад зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Америкийн Засгийн газрын тусгай байгууллага юм.

Энэ тухай Вашингтоны засаг захиргааны өндөр албан тушаалын төлөөлөгч АНУ–ын Ерөнхийлөгч Жо Байден, тус улсад айлчилж буй Украины Ерөнхийлөгч Владимир Зеленский нарын энэ оны 9 дүгээр сарын 1–ний өдөр товлосон уулзалт хийсэн тухай тусгай хэвлэлийн бага хурлын үеэр мэдээлжээ.

“Эдийн засгийн хувьд бид энэ айлчлалыг бат бэх эдийн

засгийн түншлэлээ гүнзгийрүүлэхэд ашиглана. Манай улсууд арилжааны хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах ажлыг дуусгах бөгөөд Экспорт–Импортын банк болон Украины Эдийн засгийн хөгжил, худалдаа, хөдөө аж ахуйн яамны хооронд Эксимбанкны анхны дэмжлэг болох \$3 тэрбум санамж бичигт гарын үсэг зурна” гэж тэрбээр онцлон тэмдэглэсэн байна.

Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр 380 гаруй гэрээ хэлэлцээр байгуулжээ.

ОХУ–ын Владивосток хотын Русский аралд 2021 оны 9 дүгээр сарын 2–4–ний өдрүүдэд болсон Дорнын эдийн засгийн VI чуулга уулзалтад оролцогчид 380 гаруй гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

Олон улсын болон гадаадын компаниуд, байгууллагууд, яамд, газруудтай 24 баримт бичигт гарын үсэг зурснаас Хятад улстай 9, Японтой 6, Казахстантай 3, Австри, Вьетнам, Канад, Серби, Өмнөд Солонгос, Этиоп улсуудтай тус бүр 1 гэрээ байгуулсан” гэж мэдээлэлд дурдсан байна.

Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр олон улсын болон бүс нутгийн тулгамдсан сэдвээр салбар хуралдаанууд, бизнесийн уулзалт ярилцлага, дугуй ширээний ярилцлага хэлбэрээр 100 гаруй арга хэмжээ болжээ. Форумын гол арга хэмжээ нь ОХУ–ын Ерөнхийлөгч Владимир Путин биечлэн, Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым–Жомарт Токаев, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх нарын цахим хэлбэрээр оролцсон нэгдсэн хуралдаан байлаа. Энэ жилийн чуулга уулзалтыг холимог хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 5700 гаруй хүн биечлэн оролцсон байна.

Курилийн арлуудад татварын онцгой журам нэвтрүүлнэ.

ОХУ–ын Ерөнхийлөгч Владимир Путин Курилийн арлуудад “бизнес эрхлэгчдэд зориулж, урьд өмнө байгаагүй татварын онцгой журам нэвтрүүлэхээ” мэдэгджээ.

В.Путин “Бизнес эрхлэгчдийг орлого, эд хөрөнгө, газрын албан татварыг 10 жилийн хугацаатай чөлөөлж, даатгалын шимтгэлийг мөн бууруулна. Түүнчлэн гаалийн хөнгөлөлт үзүүлнэ. Хөнгөлөлттэй журам нэвтрүүлснээр Курилийн хөгжилд, юуны өмнө аялал жуулчлал, далайн соёл, дахин

боловсруулах зэрэг салбарт ирээдүйтэй төслүүд хэрэгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулна гэж найдаж байна” хэмээн ОХУ–ын төрийн тэргүүн Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын нэгдсэн хуралдааны үеэр мэдэгджээ. Курилийн арлуудад үйл ажиллагаа явуулдаг гадаадын компаниуд мөн энэхүү онцгой нөхцөл байдлыг ашиглах боломжтой.

Япон улс Курилийн арлуудад эдийн засгийн онцгой бүс байгуулахыг эсэргүүцжээ.

Курилийн арлуудад эдийн засгийн онцгой бүс байгуулах Москвагийн төлөвлөгөө нь Токиогийн байр суурьтай нийцэхгүй байна гэж Японы сайд нарын танхимын ерөнхий нарийн бичгийн дарга Като Кацунобу мэдэгджээ.

Түүний мэдэгдсэнээр, нутаг дэвсгэрийнхээ эдийн засгийг хөгжүүлэх талаар Япон болон гадаадын компаниудад хандсан уриалга нь Кунашир, Итуруп, Шикотан, Хабомай арлуудад эдийн засгийн хамтарсан үйл ажиллагаа явуулах талаар хүрсэн хоёр улсын удирдагчдын хэлэлцээртэй зөрчилдөж байна. Тэрбээр үүсээд буй нөхцөл байдалд "маш их харамсаж байгаагаа" тэмдэглээд үүнтэй холбогдуулан өнгөрсөн баасан гарагт Японы талаас Оросын талд эсэргүүцлээ илэрхийлсэн гэжээ.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

S&P 500 /^GSPC/

4,307.54 +49.50 (+1.15%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/

29,452.66 +5.22 (+0.54%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,086.40 -59.35 (-0.84%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

14,448.58 +118.10 (+0.82%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia